



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН ХАРЬЯА
ХОВД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Мөнххайрхан сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ХОА-2026/010/НА-СТА-ТТЗ

Цахим хуудас: www.audit.mn	Ховд аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор: Х.Болдбаатар Цахим хаяг: Boldbaatar.Kh @audit.gov.mn Аудитын менежер: А.Цэцэгсүрэн Утас: 70432545
Ховд хот	Цахим хаяг: tsetsegsuren.a@audit.gov.mn
2026 он	Аудитор: С.Оюунжаргал Утас: 70432545 Цахим хаяг: Oyunjargals@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1. ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ.....	3
2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ.....	5
2.1 Аудит хийсэн нэгтгэсэн санхүүгийн байдлын тайлан	5
2.2 Аудит хийсэн нэгтгэсэн санхүүгийн үр дүнгийн тайлан.....	5
2.3 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан	6
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	7
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	8
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	9
3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	9
3.1 Зөвлөмж.....	9
4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ	11
5. ТӨСВИЙН ЗАХИРАГЧИЙН АНГИЛЛААР АУДИТАД ХАМРАГДСАН БАЙДАЛ БА САНАЛ ДҮГНЭЛТИЙН ТАЛААРХ МЭДЭЭЛЛИЙН НЭГТГЭЛ.....	11

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТТЗ	Төсвийн төвлөрүүлэн захирагч
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
НА	Нийцлийн аудит
СТА	Санхүүгийн тайлангийн аудит

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



ХОВД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

84000 Цамбагарав баг, Жаргалант сум, Ховд аймаг
Утас/Факс: (976)-7043-3061
Email: khovd@audit.gov.mn

2026.03.23 № 261

танай _____ -ны № _____ -т

МӨНХХАЙРХАН СУМЫН ТӨСВИЙН
ТӨВЛӨРҮҮЛЭН ЗАХИРАГЧ
Б.БАТЗАЯА ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу Ховд аймгийн Мөнххайрхан сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Тайлант онд төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2025 онд хэрэгжүүлэх 8 хөтөлбөрийн 26 арга хэмжээний зардалд 2,244.9 сая төгрөгийн төсөв батлагдсанаас гүйцэтгэлээр 1,924.5 сая төгрөгийг зарцуулснаас 1,618.2 сая төгрөгийг урсгал зардалд, 306.4 сая төгрөгийг ОНХС-ийн шилжих болон шинээр эхлэх 17 хөрөнгө оруулалт, хөтөлбөр арга хэмжээнд тус тус зарцуулсан байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Мөнххайрхан сум нь татварын болон татварын бус орлогоор нийт 612.7 сая төгрөгийн орлого бүрдүүлж, орлогыг төлөвлөгөөг 45.7 сая төгрөг буюу 8 хувиар давуулан бүрдүүлсэн байна.

84260506-5

Бусад асуудлын хэсэг

Мөнххайрхан сумын "Алаг" багийн 90 жилийн ойн баяр наадмыг аймгийн иргэдийн төлөөлөгчдийн хурын тогтоол шийдвэргүйгээр тэмдэглэн өнгөрүүлж 30.5 сая төгрөгийн хандивын орлого бүрдүүлж данс бүртгэлд тусгаагүй байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Х.БОЛДБААТАР

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн нэгтгэсэн санхүүгийн байдлын тайлан

(мян.төгрөгөөр)

№	Дансны нэр, төрөл	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
1	1. ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	547,057.31	587,005.26
2	1.1.1 МӨНГӨН ХӨРӨНГӨ	332,436.1	403,471.89
3	1.1.3 АВЛАГА	64,057.31	39,658.96
4	1.1.4 УРЬДЧИЛГАА	40,440.00	31,120.0
5	1.1.5 БАРАА МАТЕРИАЛ	70,843.9	78,991.9
6	1.1.6 НӨӨЦИЙН БАРАА	39,280	33,762.5
7	1.2 ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	2,918,083.68	2,982,726.87
8	1.2.2 ҮНДСЭН ХӨРӨНГӨ	2,918,083.68	2,982,726.87
9	1.2.2.02 Биет хөрөнгө	2,825,417.28	2,890,060.47
10	1.2.2.03 Биет бус хөрөнгө	92,666.4	92,666.4
11	1 НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	3,465,140.98	3,569,732.13
12	2.1 НИЙТ ӨР ТӨЛБӨР	19,138	19,222.07
13	2.1.1 БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	19,138	19,222.07
14	2.1.1.03 Өглөг	19,138	19,222.07
15	2.2 ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	3,446,002.98	3,550,510.06
16	2.2.1 Засгийн газрын хувь оролцоо	3,446,002.98	3,550,510.06
17	2.2.1.01 Засгийн газрын оруулсан капитал	1,146,916.9	1,146,916.9
18	2.2.1.08 Хуримтлагдсан үр дүн	2,218,903.61	2,323,410.69
19	2.2.1.09 Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	80,182.48	80,182.48
20	2 ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	3,465,140.98	3,569,732.13

2.2 Аудит хийсэн нэгтгэсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

(мян.төгрөгөөр)

№	Дансны нэр, төрөл	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
1	1.1.1 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН	2,603,415.78	2,360,913.15
2	1.1.1.03 ТАТВАРЫН ОРЛОГО	605,099.16	611,325.12
3	1.1.1.03.1 Орлогын албан татвар	449,894.08	451,222.05
4	1.1.1.03.1.01 Хувь хүний орлогын албан татвар	468,693.1	484,213.96
5	1.1.1.03.1.02 Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	-18,799.02	-32,991.91
6	1.1.1.03.3 Хөрөнгийн албан татвар	39,511.89	37,347.87
7	1.1.1.03.8 Бусад татвар, төлбөр, хураамж	115,693.18	122,755.21
8	1.1.1.04 ТАТВАРЫН БУС ОРЛОГО	354,309.97	1,749,588.02
9	1.1.1.04.3 Тусламжийн орлого	0.0	1,140,859.47
10	1.1.1.05 ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,644,006.66	0.0

11	1.1.2 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	2,485,066.36	2,262,393.34
12	1.1.2.01 УРСГАЛ ЗАРДАЛ	2,477,204.56	1,955,795.1
13	1.1.2.01.1 БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,380,738.21	1,919,371.44
14	1.1.2.01.1.01 Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	739,473.07	851,612.99
15	1.1.2.01.1.02 Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	92,235.65	105,869.03
16	1.1.2.01.1.03 Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	488,465.8	495,838.88
17	1.1.2.01.1.04 Хангамж, бараа материалын зардал	488,216.68	27,735.51
18	1.1.2.01.1.05 Нормативт зардал	786	426
19	1.1.2.01.1.06 Эд хогшил, урсгал засварын зардал	15,515.89	23,092.6
20	1.1.2.01.1.07 Томилолт, зочны зардал	9,254.6	9,813.5
21	1.1.2.01.1.08 Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	63,961.16	55,437.58
22	1.1.2.01.1.09 Бараа үйлчилгээний бусад зардал	482,829.37	349,545.36
23	1.1.2.01.4 УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	96,466.34	36,423.66
24	1.1.2.02 ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	7,861.8	306,598.24
25	1.1 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	118,349.43	98,519.81
26	1.2.2 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	6,887.51	3,301.03
27	1.2 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (VII)=(IV)-(V)	-6,887.51	-3,301.03
28	1 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(VII)	111,461.92	95,218.77

2.3 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

(мян.төгрөгөөр)

№	Дансны нэр, төрөл	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
1	1.1.1.1 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН	2,237,129.59	2,092,453.99
2	1.1.1.1.03 ТАТВАРЫН ОРЛОГО	605,099.16	611,325.12
3	1.1.1.1.03.1 Орлогын албан татвар	449,894.08	451,222.05
4	1.1.1.1.03.1.02 Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	-18,799.02	-32,991.91
5	1.1.1.1.03.3 Хөрөнгийн албан татвар	39,511.89	37,347.87
6	1.1.1.1.03.8 Бусад татвар, төлбөр, хураамж	115,693.18	122,755.21
7	1.1.1.1.03.8.01 Бусад нийтлэг төлбөр, хураамж	23,965.83	24,493.28
8	1.1.1.1.03.8.02 Газрын төлбөр	5,236.01	8,826.91
9	1.1.1.1.03.8.03 Байгалийн нөөц ашигласны төлбөр	86,491.35	89,435.02
10	1.1.1.1.04 ТАТВАРЫН БУС ОРЛОГО	13,815.08	1,481,128.86
11	1.1.1.1.04.1 Нийтлэг татварын бус орлого	13,815.08	34,958.69
12	1.1.1.1.04.3 Тусламжийн орлого	0.0	1,181,580.78
13	1.1.1.1.04.4 Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	0.0	264,589.4
14	1.1.1.1.05 ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,618,215.35	0.0
15	1.1.1.2 НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,580,557.43	1,711,834.55

16	1.1.1.2.01 УРСГАЛ ЗАРДАЛ	1,580,557.43	1,711,834.55
17	1.1.1.2.01.1 БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,484,091.09	1,675,410.89
18	1.1.1.2.01.1.01 Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	738,891.63	852,439.54
19	1.1.1.2.01.1.02 Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	92,691.69	106,566.51
20	1.1.1.2.01.1.03 Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	488,465.8	495,665.06
21	1.1.1.2.01.1.04 Хангамж, бараа материалын зардал	34,071.76	27,298.91
22	1.1.1.2.01.1.05 Нормативт зардал	552	388
23	1.1.1.2.01.1.06 Эд хогшил, урсгал засварын зардал	15,008.39	19,198.6
24	1.1.1.2.01.1.07 Томилолт, зочны зардал	9,379.6	9,813.5
25	1.1.1.2.01.1.08 Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	65,795.66	63,287.52
26	1.1.1.2.01.1.09 Бараа үйлчилгээний бусад зардал	39,234.58	100,753.25
27	1.1.1.2.01.4 УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	96,466.34	36,423.66
28	1.1.1 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	656,572.15	380,619.44
29	1.1.2.2 ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН	669,647.12	306,981.44
30	1.1.2.2.01 ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	669,647.12	306,981.44
31	1.1.2.2.01.1 Дотоод эх үүсвэрээр	669,647.12	306,981.44
32	1.1.2 ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-669,647.12	-306,981.44
33	1.1.3.2 ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	6,887.51	2,602.2
34	1.1.3 САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	-6,887.51	-2,602.2
35	1.1 НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	-19,962.48	71,035.79
36	1.2 Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	352,398.58	332,436.1
37	1 Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	332,436.1	403,471.89

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

(мян.төгрөгөөр)

№	Дансны нэр, төрөл	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн	Нийт цэвэр хөрөнгө /өмч
1	1.1.1.1.1.1 2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	3,356,986.07	3,356,986.07
2	1.1.1.1.1.2 Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-22,445.00	-22,445.00
3	1.1.1.1.1 Дахин илэрхийлсэн үлдэгдэл	3,334,541.07	3,334,541.07
4	1.1.1.1.7 Тайлант үеийн үр дүн	111,461.92	111,461.92
5	1.1.1.1 2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	3,446,002.98	3,446,002.98
6	1.1.1 2025 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	3,446,002.98	3,446,002.98

7	1.1.2 Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	9,288.30	9,288.30
8	1.1 Дахин илэрхийлсэн үлдэгдэл	3,455,291.29	3,455,291.29
9	1.7 Тайлант үеийн үр дүн	95,218.77	95,218.77
10	2025 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	3,550,510.06	3,550,510.06

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

(мян.төгрөгөөр)

Дансны код	Дансны нэр, төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	3.1.01.1 НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	1,969,162.00	2,038,187.41
11	3.1.01.1.1 Татварын орлого	563,853.40	611,325.12
110	3.1.01.1.1.1 Орлогын албан татвар	414,678.20	451,222.05
1100	3.1.01.1.1.1.1 Хувь хүний орлогын албан татвар	447,670.10	484,213.96
1101	3.1.01.1.1.1.2 Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	(32,991.90)	(32,991.91)
113	3.1.01.1.1.3 Хөрөнгийн албан татвар	37,000.00	37,347.87
118	3.1.01.1.1.8 Бусад татвар, төлбөр, хураамж	112,175.20	122,755.21
1180	3.1.01.1.1.8.1 Бусад нийтлэг төлбөр, хураамж	23,800.00	24,493.28
1181	3.1.01.1.1.8.2 Газрын төлбөр	6,625.20	8,826.91
1182	3.1.01.1.1.8.3 Байгалийн нөөц ашигласны төлбөр	81,750.00	89,435.02
12	3.1.01.1.2 Татварын бус орлого	1,405,308.60	1,426,862.29
120	3.1.01.1.2.1 Нийтлэг татварын бус орлого	13,405.00	34,958.69
122	3.1.01.1.2.3 Тусламжийн орлого	1,127,314.20	1,127,314.20
123	3.1.01.1.2.4 Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	264,589.40	264,589.40
II	3.1.01.2 НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,244,868.40	1,950,327.57
21	3.1.01.2.1 УРСГАЛ ЗАРДАЛ	1,731,503.00	1,640,743.92
210	3.1.01.2.1.1 БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,721,994.00	1,640,418.92
2101	3.1.01.2.1.1.1 Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	910,906.20	852,439.54
2102	3.1.01.2.1.1.2 Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	113,863.40	106,566.51
2103	3.1.01.2.1.1.3 Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	503,160.80	495,665.06
2104	3.1.01.2.1.1.4 Хангамж, бараа материалын зардал	25,967.30	22,167.81
2105	3.1.01.2.1.1.5 Нормативт зардал	683.20	388.00
2106	3.1.01.2.1.1.6 Эд хогшил, урсгал засварын зардал	22,797.40	19,198.60
2107	3.1.01.2.1.1.7 Томилолт, зочны зардал	11,145.70	9,813.50
2108	3.1.01.2.1.1.8 Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	65,881.60	50,224.95
2109	3.1.01.2.1.1.9 Бараа үйлчилгээний бусад зардал	67,588.40	83,954.95
213	3.1.01.2.1.4 УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	9,509.00	325.00
2131	3.1.01.2.1.4.1 Засгийн газрын урсгал шилжүүлэг	-	-
2132	3.1.01.2.1.4.2 Бусад урсгал шилжүүлэг	9,509.00	325.00
22	3.1.01.2.2 ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	352,585.80	306,981.44
23	3.1.01.2.3 ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	160,779.60	2,602.20

8	3.1.01 ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН НИЙТ ТЭНЦЭЛ	(275,706.40)	87,859.84
9	3.1 АЛДАГДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	275,706.40	87,859.84
7	3 Харилцах болон хадгаламжийн дансны цэвэр өөрчлөлт	275,706.40	87,859.84
4	4 Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	332,436.10
5	5 Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	403,471.89

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

(мян.төгрөгөөр)

Дансны код	Дансны нэр, төрөл	1. Тайлант он
1	1.1.1.1 НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	54,266,578.0
12	1.1.1.1.1 ТАТВАРЫН БУС ОРЛОГО	54,266,578.0
122	1.1.1.1.1.1 Тусламжийн орлого	54,266,578.0
1221	1.1.1.1.1.1.1 Хандив тусламж /дотоод/	54,266,578.0
12213	1.1.1.1.1.1.1.1 Нэмэлт санхүүжилтийн орлого	54,266,578.0
350013	1.1.1.1.1.1.1.1.3 ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	33,549,510.0
350014	1.1.1.1.1.1.1.1.4 Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	1,402,968.0
350015	1.1.1.1.1.1.1.1.5 Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	19,314,100.0
II	1.1.1.2 НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	34,991,968.0
21	1.1.1.2.1 УРСГАЛ ЗАРДАЛ	34,991,968.0
210	1.1.1.2.1.1 БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	34,991,968.0
2104	1.1.1.2.1.1.4 Хангамж, бараа материалын зардал	5,131,100.0
2108	1.1.1.2.1.1.8 Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	13,062,568.0
2109	1.1.1.2.1.1.9 Бараа үйлчилгээний бусад зардал	16,798,300.0
4	1.1.1 ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН НИЙТ ТЭНЦЭЛ	19,274,610.0
5	1.1 АЛДАГДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	(19,274,610.0)
6	1 Харилцах болон хадгаламжийн дансны цэвэр өөрчлөлт	(19,274,610.0)

3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 32,450.0 мянган төгрөгийн зөрчил¹ илэрснээс 32,450.0 мянган төгрөгийн 2 заалт бүхий зөвлөмж өглөө.

Залруулагдаагүй материаллаг зөрчил нь тогтоосон гүйцэтгэлийн материаллаг байдлын дүн 39,051.23 мянган төгрөгөөс бага байгаа тул “Өөрчлөлтгүй” дүгнэлт өгсөн.

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

3.1 Зөвлөмж

3.1.1 Хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой асуудал

¹ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Илрүүлэлт: Аймгийн тэмдэглэлт баяр ёслол арга хэмжээний жагсаалтад ороогүй, ИТХ-ын тогтоол шийдвэр гараагүй байхад Мөнххайрхан сумын Алаг багийн 90 жилийн ойг тэмдэглэн өнгөрүүлсэн, хандивын орлогыг данс бүртгэлд тусгаагүй нь Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.2.Аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал энэ хуулийн 4, 5 дугаар зүйлд зааснаас бусад орон нутгийн хэмжээнд тэмдэглэх тэмдэглэлт өдрийг тогтоож, тэдгээрийг тэмдэглэн өнгөрүүлэх журам, зардлыг батална, Төсвийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.7-д "Тусламж, хандивын орлогыг холбогдох журмын дагуу бүртгэж, гүйцэтгэлийг тайлагнана." Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4.5-д "бүх орлого" гэсэн заалт, санхүүгийн тайлагналын иж бүрэн, тасалбар болголт, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Эрх бүхий байгууллагын шийдвэргүйгээр ой тэмдэглэдэг байдлыг таслан зогсоож, дотоод хяналтыг үр нөлөөтэй хэрэгжүүлэн ажиллах .

3.1.2 Орон нутгийн хөгжүүлэх сантай холбоотой асуудал

Илрүүлэлт: Сумын засаг даргын А/32 дугаар захирамжаар иргэдээс санал авч эрэмбэлэгдээгүй хөх тэнгэрийн эсгий туургатан нэвтрүүлгийн зардалд 4,000.0 мянган төгрөгийн гэрээ байгуулж 2,000.0 мянган төгрөг олгож төсвийн үргүй зардал гаргасан нь Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журмын 4 дүгээр зүйлийн 4.3.1-д “ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээ нь Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан урт, дунд болон богино хугацааны хөгжлийн бодлогын баримт бичгүүдтэй уялдсан байх” 4.3.2-д “ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээ нь тухайн орон нутгийн иргэдийн саналаар дэмжигдэж эрэмбэлэгдсэн байх”, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15.1.4-д ”Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлиг, Улсын Их Хурлаас баталсан хууль тогтоомж, Засгийн газрын болон аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг даргын шийдвэр, тэдгээрийн хэрэгжилт, цаг үеийн шинжтэй мэдээ, мэдээллийг олон нийтэд хүргэх, сурталчлан таниулахаас бусад зорилгоор байгууллага, хамт олныг сурталчлах, салбарын болон байгууллагын үйл ажиллагаатай холбоотой нэвтрүүлэг, контент, баримтат болон цуврал киноны уран бүтээл зэргийг санхүүжүүлэх” гэсэн заалт, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: *ОНХС-ийн журмын дагуу орон нутгийн иргэдээс санал авсан арга хэмжээг санхүүжүүлэх*

Дээрх зөвлөмжийн биелэлтийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5-д “Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-г заасан зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ” гэж заасны дагуу зөвлөмжийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг 2026 оны 04 дүгээр сарын 25-ны өдрийн дотор fas.audit.mn системд тайлагнан ажиллана уу.

Шийдвэрийн хэрэгжилтийг бүрэн хангуулж биелэлтийг Fas.audit.mn цахим системд нотлох баримтын хамт тайлагнан, Ховд аймаг дахь Төрийн аудитын байгууллагад 2026 оны 08 дугаар сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

4.1 Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Алдаа, зөрчлийн товч утга	Нийт алдаа, зөрчлийн дүн		Үүнээс:							
		Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн	
				Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12
Мөнххайрхан сумын Засаг дарга	Тогтоол шийдвэргүй багийн ой тэмдэглэн хандивын орлогыг данс бүртгэлд тусгаагүй	1	30,450.0					1	30,450.0		
Орон нутгийн хөгжлийн сан	Иргэдээс санал авч эрэмбэлэгдээгүй, хөх тэнгэрийн эсгий туургатан нэвтрүүлгийн зардлыг санхүүжүүлж төсвийг үрэлгэн зарцуулсан	1	2,000.0					1	2,000.0		
ДҮН			32,450.0					2	32,450.0		

5. ТӨСВИЙН ЗАХИРАГЧИЙН АНГИЛЛААР АУДИТАД ХАМРАГДСАН БАЙДАЛ БА САНАЛ ДҮГНЭЛТИЙН ТАЛААРХ МЭДЭЭЛЛИЙН НЭГТГЭЛ

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр				
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан	
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй					
А	1	2	3	4	5	7	8	9	10	
1	ТТЗ	1	1			1				
	НИЙТ	1	1			1				